








**Дараах дүрснээс хамгийн  
таалагдаж буй нэгийг сонгоорой**





- Тэд аливаа ажлыг хийхдээ хүмүүсийн бодол санааг ихэд чухалчилдаг.
- Тиймээс шийдвэр гаргахдаа хатуу байр суурь баримтлахаас аль болох зайлсхийдэг.
- Бусдыг сонсож, бусдын сэтгэл санааг хуваалцдаг.
- Бусдын баяр баясгалан, уйтгар гунигийг өөрийнх адил хүлээж тусгадаг. Иймээс ч та хүмүүст таалагддаг.
- Хүнийг маш сайн танидаг бөгөөд худалч, хуурамчийг таних чадвартай.
- Хэн нэгэнтэй зөрчилд орвол түрүүлж буулт хийх хандлагатай.



- Аливаа ажил, үйл ажиллагаанд оролцохдоо ялах, хожих, амжилтанд хүрэх хүслээр дүүрэн.
- Асуудалтай тулгарахдаа тэсвэргүй, асуудлыг шийдвэрлэхдээ гуйвдаг хүмүүсийг тэсвэрлэж чаддаггүй.
- Маш сайн менежер байж чаддаг.
- Өөрсдийн алдаа дутагдлыг хүлээх дургүй, өөрийнхөөрөө зүтгэдэг.
- Прагматик баримжаа, гол зорилтонд дэм болох мэдээллийг оновчтой тусган хүлээж авч чаддаг.
- Ашигтай байдлын төлөө өрсөлдөгчидтэйгээ тулж чаддаг.



- Хөдөлмөрч, ядарч цуцахаа мэдэлгүй зүтгэлтэй ажилладаг.
- Аливаа зүйлийг эмх цэгцтэй байхад дуртай.
- Төлөвлөгөө, үйл явдлын дараалал гэнэтийн байдлаар өөрчлөгдөхөд нааштай хүлээж авдаггүй.
- Үргэлж хүрээлэн буй орчин, эд зүйлийг эмхэлж, ажил даалгаврыг зохион байгуулж явдаг.
- Сайн зохион байгуулагч, үүрэг гүйцэтгэгч боловч сайн захирагч, менежер байх нь ховор.
- Сэтгэлийн хөдөлгөөний илрэл багатай, хөндий хүйтэн байдал нь хүнтэй танилцан, холбоо тогтооход саад тотгор болдог.



- Өсөлт, өөрчлөлтийг хүсэж, түүндээ хүрэх арга замаа судалдаг.
- Бүх л зүйлийг сонирхсон зоригтой байдал нь бусдаас онцгой болгодог. Гэвч хэт итгэмтгий, гэнэн зан илэрч болдог.
- Бусдын байдлыг ажиглан шалгадаг ба сониуч зангаасаа үүдэн урьдаас таамаглахын аргагүй шийдвэр гаргадаг.
- Зарим үед бусдаас болгоожилсон, айж цэрвэсэн байдалтай байх нь бий.
- Амьдралын ноён нуруугүй хүмүүсээс санаатайгаар зугатан харилцаа, холбоо тогтоохоос болгоомжилдог байна.



- Бусдаас өвөрмөц сэтгэгч, бүтээлч хүн юм.
- Шинэ үзэл баримтлал дэвшүүлэн маргааныг шийдвэрлэх сонирхолтой байдаг.
- Байнгын өөрчлөлт хувиралд дуртай тул нэгэн хэвийн зүйл, заавар, дүрэм, байр байрлал, хүмүүс түүнийг уйдаадаг.
- Зохион байгуулагдсан орчинд үр бүтээлтэй ажиллаж чаддаггүй. Ажил дээр бусдаас хамаарахгүй байхыг эрмэлздэг.
- Шинэ санаагаа хэрэгжүүлэхэд тэсвэр дутах магадлалтай.
- Тодорхой зүйлийг бодит зүйл болгох, аливааг эцэст нь хүргэх хатуужилгүй байдаг.